



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/86

Хужирт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Төвлөрсөн хог хаягдлын цэгийг дарж булах ӨВАХУСЗДТГ/202301008" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Мөнхбат (Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Д.Уранчимэг (Санхүүгийн албаны дарга)

Б.Бямбасүрэн (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)


Ш.Эрдэнэхорол (Иргэний төлөөлөл-зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: Л.Цэдэв (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу архивын нэгж бүрдүүлэн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Л.Цэдэв)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ